

Баян-Олгий аймгийн Засаг дарга Х.Дармен цаг үеийн ажлын талаар аймгийнхаа иргэдэд мэдээлэл хийлээ.

Тэрээр ярихдаа,А аймагт уулын хадлан шувтарч голын хадлан бэлтгэх толовлогоо 60 орчим хувьд хүрсэн, малчид хашаа хороогоо засч байгаа, Олгий сумын нэгдсэн халаалтын зуухны бэлтгэл 90 хувьтай болсон нь нэгдсэн ажлын биелэлт 60 хувиас дээш байна. Ерөнхий боловсролын 43 сургууль 1400 багштай, 22800 гаруй хvvхэд суралцахаар шинэ хичээлийн нээлтээ хийхэд бэлэн болсон. Омнох он жилvvдэд зарим сургуулийн захиргаад тосов санхvvгийн хууль зорчин илvv орон тоо нэмсэн зорчлийг арилгаж илvvдсэнийг нь чолоолно. Энэ бол дээрээс орон тоо цомхотгож байгаа явдал биш, омнох алдааг залруулж байгаа хэрэг мон гэж ойлговол зохино.

А А Орон нутгийг хогжvvлэх сангийн хоронго болон тосвийн хоронгоор бvтээн байгуулах зvйлvvд тогтоогдсон цаг хугацааныхаа дагуу хэрэгжиж байна. Олгийд эмнэлгийн хоёр байгууламж барьж байна. Гудамж талбайн гэрэлтvvлэг, хяналтын камер суурилуулах, тов талбайг тохижуулах ажил эхлэхээр болж байна. Тендерт оролцогч хоёр аж ахуйн нэгжийн хоорондын маргаанаас vvдээд нэг л байгууламж барих ажил хугацаа алдсан бусад vзvvлэлт оны эцэс хүртэл хэрэгжинэ. Цэнгэл сумыг шинэ сумын хотолбороор шинэчлэн хогжvvлэх ажлыг «Агайн» компани гардан гvйцэтгэж, ажил нь урагштай байна. Энэ суманд соёлын тов, хvvхдийн цэцэрлэгийн байр, цэвэр бохир усны суваг, дулааны шугам зэрэг инженерийн байгууламж, уртаашаа найман зуун метр хар зам болон явган хvний зам тавих зэрэг иж бvрэн ажил явагдаж байна.

А Мон ариун цэвэр эрvvл ахуйн шаардлага болон хойч үеийнхэнд чухал ач холбогдолтой гэж vзээд хуучин захууд дээр байрлан vйлчилж байсан мах, сvv, хvнсний ногооны худалдааг хотын зах дээр цэвэр орчинд байгуулагдсан шинэ битvv захад шилжvvлж байгаа тухай Засаг дарга тайлбарлан ярилаа.